



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

**ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ БОЛОН РАДИО,
ТЕЛЕВИЗИЙН ГАЗРЫН СҮЛЖЭЭНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ГЭРЭЭНИЙ
ҮҮРГИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТЫН ТАЙЛАН**

2026.02.26-03.20

ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

УЛААНБААТАР ХОТЫН ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ БОЛОН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ГАЗРЫН СҮЛЖЭЭНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТЫН ТАЙЛАН

Улаанбаатар хотод “Олон суваг дамжуулах үйлчилгээ” болон “Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ” эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналтыг Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ)-ны даргын 2026 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/44 тоот тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу 2026 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс 03 дугаар сарын 20-ны өдрийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Тодруулбал, үйлчилгээ эрхлэгчдийн тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилт, ашиглаж буй сүлжээ, технологийн шийдэл, нэвтрүүлэх станцын техник, тоног төхөөрөмжийн бүрдэл, тэдгээрийн ашиглалт, ажиллагааны байдалд үзлэг, хяналт хийв.

Мөн дамжуулж буй телевизийн сувгуудын дохионы чанар (дуу, дүрсний чанар), дамжуулалтын найдвартай байдал, үйлчилгээний тасралтгүй ажиллагааны нөхцөл байдалд үнэлгээ хийж, үйлчилгээ үзүүлэхэд ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн суурилуулалт, ашиглалтын нөхцөл, техникийн баримт бичгийн бүрдүүлэлт, үйлчилгээний чанарын хяналт, тайлан мэдээний гаргалт, ирүүлсэн байдал, түүнчлэн үйл ажиллагаатай холбоотой гэрээ, баримт бичгийн бүрдэлд хяналт тавьж ажилласан.

Төлөвлөгөөт хяналтын зорилго нь Зөвшөөрлийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль болон эдгээрт нийцүүлэн ХХЗХ-ноос баталсан нөхцөл, шаардлага, журмын хэрэгжилт, тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн биелэлтийг үнэлэх, дүгнэх юм.

ХЯНАЛТ ХИЙСЭН ЧИГЛЭЛ:

1. Тусгай зөвшөөрөл, баримт бичиг:

- Статистик болон эзэмшлийн мэдээллийг тогтоосон хугацаанд ирүүлсэн байдал.
- Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйлчилгээний хөлсний төлөлт
- Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний боловсруулалт, бэлэн байдал.
- Үйлчилгээний найдвартай, тасралтгүй ажиллагааны журмын мөрдөлт.
- Хэрэглэгчийн төхөөрөмжийн баталгаажуулалт.

2. Техникийн бэлэн байдал ба найдвартай ажиллагаа:

- Тоног төхөөрөмжийн, цахилгаан тэжээлийн нөөц эх үүсвэрийн хангамж;
- Сүлжээний хяналтын удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн байдал;
- Тогтмол үзлэг, үйлчилгээний бүртгэл хөтлөлт, техникийн бэлэн байдал;
- Гамшгийн зарлан мэдээллийг нийтэд дамжуулах техникийн боломж;
- Тасралтгүй ажиллагааны түвшний тайлагналт;

3. Үйлчилгээний чанарт тавих шаардлага:

- Телевизийн сувгийн дуу, дүрсний дохионы стандарт (QoS) хэмжилт, үзүүлэлт.
- Үйлчилгээний чанарт хийсэн хэмжилт, судалгааны бүртгэл.
- Радио, телевиз дамжуулах болон техник холболтын гэрээний хэрэгжилт.

4. Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр:

- Хэрэглэгчийн санал, гомдол хүлээн авах, шийдвэрлэх журмын мөрдөлт;

- Контентын ангилал, эцэг эхийн хяналтын систем (Parental Control) бүрдүүлэлт;
- Суваг хаах, түгжих, нууц үг солих зааварчилгааны хүртээмж;

5. Радио, телевизийг дамжуулах, гэрээ байгуулахад тавих шаардлага

6. Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын журмын шаардлага

Дээрх 6 чиглэлийн хүрээнд үйлчилгээ эрхлэгчид холбогдох хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан журам, нөхцөл шаардлага, тусгай зөвшөөрлийн гэрээний хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаад хяналт тавьж ажилласан. Мөн үйл ажиллагааны явцад үүсэж буй хүндрэл, бэрхшээл, тулгамдсан асуудлыг сонсож, судлан шинжилж, холбогдох заавар зөвлөмж өгч, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, үйл ажиллагааг сайжруулах талаар шаардлагатай арга хэмжээг авах үүрэг, чиглэл өгч ажиллалаа.

ХЯНАЛТАД ХАМРАГДСАН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧИД:



Хяналтад нийт хамрагдсан 12 үйлчилгээ эрхлэгчээс Монгол Улсад хамрах хүрээтэй 7, Улаанбаатар хотын хамрах хүрээтэй 3, Улаанбаатар хот болон бусад аймгийн хамрах хүрээтэй 2 үйлчилгээ эрхлэгч байна.


Дээрх үйлчилгээ эрхлэгчдээс 1 нь үйлчилгээг шинэчлэх зорилгоор үйл ажиллагаагаа түр хугацаагаар зогсоосон, 4 үйлчилгээ эрхлэгч нь зохицуулалтын үйлчилгээний хөлсний төлбөрийн үлдэгдэлтэй байсан.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, БАРИМТ БИЧИГ:

Үйлчилгээ эрхлэгчид статистик тайлан, мэдээ болон эзэмшлийн мэдээллийг батлагдсан маягт, тогтоосон хугацааны дагуу цаг тухайд нь ирүүлж, тайлагнах үүргийн хэрэгжилтийг ханган ажилласан. Мөн бүх үйлчилгээ эрхлэгч гамшгийн үеийн нэгдсэн удирдлагын тогтолцоог бүрдүүлж, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулан баталсан нь эерэг үзүүлэлттэй байна.

Түүнчлэн үйлчилгээний найдвартай ажиллагааг хангах чиглэлээр 12 үйлчилгээ эрхлэгчээс 11 нь холбогдох журмыг боловсруулан баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байгаа бол 1 үйлчилгээ эрхлэгч (“Оптимум нэтворкс” ХХК) уг журмыг батлаагүй, шаардлагыг хангаагүй.

Хэрэглэгчийн төхөөрөмжийн баталгаажуулалтын хувьд 7 үйлчилгээ эрхлэгч баталгаажуулалтыг хийж, холбогдох шаардлагыг ханган ажиллаж байгаа бол үлдсэн үйлчилгээ эрхлэгчид уг шаардлагыг бүрэн хангаагүй байна. Мөн радио нэвтрүүлэх станцын тоног төхөөрөмжийн баталгаажуулалтын хувьд 7 үйлчилгээ эрхлэгч баталгаажуулалт хийгдээгүй байгаа нь цаашид анхаарч сайжруулах шаардлагатай гэж үзлээ.



ТЕХНИКИЙН БЭЛЭН БАЙДАЛ БА НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГАА:

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн хувьд нийт 11 үйлчилгээ эрхлэгч бүгд тоног төхөөрөмж болон цахилгаан тэжээлийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор нөөц эх үүсвэрийг бүрдүүлэн ажиллаж байна. Энэ нь үйлчилгээний тасралтгүй, найдвартай байдлыг хангах, гэнэтийн саатал үүсэх эрсдэлийг бууруулах чухал нөхцөл болж буй юм. Харин радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн хувьд цахилгаан тэжээлийн болон тоног төхөөрөмжийн нөөцийн бүрдүүлэлт хангалтгүй байгаа нь үйлчилгээний тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Гамшиг, онцгой байдлын үед мэдээ, мэдээллийг шуурхай дамжуулах боломжийг бүрдүүлсэн 8 үйлчилгээ эрхлэгч байгаа бол 4 үйлчилгээ эрхлэгч (“Монголын цахилгаан холбоо” ХК, “Сансар Дижитал” ХХК, “Ори медиа” ХХК, “Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ) нь ийм төрлийн систем, зохион байгуулалтын шийдлийг бүрэн нэвтрүүлээгүй байна.

Тоног төхөөрөмжийн ашиглалт, найдвартай ажиллагааг хангах чиглэлээр үзлэг, үйлчилгээний хуваарийг батлуулан мөрдөж байгаа эсэхийг шалгахад 11 үйлчилгээ эрхлэгч нь холбогдох журам, зааврыг батлан мөрдөж, үзлэг үйлчилгээний хуваарийг жил, сар, долоо хоногоор нарийвчлан батлуулж, төлөвлөгөөний дагуу тогтмол үзлэг үйлчилгээ хийж, бүртгэл хөтлөн ажиллаж байна. Энэ нь техникийн бэлэн байдлыг хангах, эвдрэл гэмтлээс урьдчилан сэргийлэхэд эерэг үзүүлэлт болж байна.

Холбогдох журмын хэрэгжилтийн хүрээнд систем болон сувгийн тасралтгүй ажиллагааны түвшний тайланг (ТАТ) ирүүлээгүй 2 үйлчилгээ эрхлэгч (Оптимум нэтворкс

ХХК, Монголсат нэтворкс ХХК) байгаа ба тайланг сар бүр тогтмол ирүүлэх талаар зөвлөж ажилласан.

Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгч нь 360 сум, суурин газарт тоон телевизийн үйлчилгээг иргэдэд үнэ төлбөргүй хүргэдэг төрийн үйлчилгээ бөгөөд хэрэглэгчийн бүртгэл хийх шаардлагагүй тул нөхцөлт хандалтын систем нэвтрүүлээгүй. Харин олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид нь үйлчилгээний онцлогоос хамааран нөхцөлт хандалтын болон цахим орчны хандалтын системүүдийг нэвтрүүлж, үйлчилгээний хүртээмж, хандалтыг зохих түвшинд хянаж, зохицуулан ажиллаж байна.

Мөн радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгч нь сүлжээ, тоног төхөөрөмжийн төвлөрсөн хяналтын нэгдсэн тогтолцоог бүрэн бүрдүүлээгүй байгаа нь алсын зайнаас хяналт тавих, саатлыг шуурхай илрүүлэх, засвар үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлэх боломжийг хязгаарлаж байгаа бол олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид бүгд хяналтын тогтолцоог бүрдүүлжээ.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРТ ТАВИХ ШААРДЛАГА:

Дууны түвшний хувьд Европын өргөн нэвтрүүлгийн холбооноос баталсан EBU R128 зөвлөмж, түүнчлэн холбогдох үндэсний стандартын шаардлагын хэрэгжилтийг шалгахад бүх үйлчилгээ эрхлэгчид дууны түвшнийг зохих хэмжээнд баримтлан дамжуулж, хэрэглэгчдэд хүргэж байна. Энэ нь хэрэглэгчдэд стандартын шаардлага хангасан дууны чанартай үйлчилгээ үзүүлж байгааг илтгэнэ.

Мөн телевизийн дүрсийн чанарын хувьд MNS 5592-2 үндэсний стандартад заасан үзүүлэлтүүдийг хангаж ажилласан бөгөөд бүх үйлчилгээ эрхлэгч дүрсийн чанарыг стандартын доод хэмжээнээс бууруулахгүйгээр дамжуулж техникийн шаардлагыг бүрэн хангаж байна.

Дамжуулж буй радио, телевизийн дохионд хэмжилт, тохируулга хийхтэй холбоотой дотоод зохицуулалтын хэрэгжилтийг авч үзэхэд 10 үйлчилгээ эрхлэгч нь энэ талаар дотоод журамд тусган, тогтсон хуваарийн дагуу тогтмол хэмжилт, тохируулга хийж, хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна. Харин 2 үйлчилгээ эрхлэгч (“Оптимум нэтворкс” ХХК, “Шинэ сансар” ХХК) энэхүү шаардлагыг дотоод журамдаа тусгаагүй, мөн тогтмол мөрдөх хэмжилт, тохируулгын хуваарь батлаагүй байна.

Хэрэглэгчийн төхөөрөмжөөр дамжуулан гадаад, дотоодын телевизийн сувгийг хүлээн авч дахин дамжуулж байгаа 2 үйлчилгээ эрхлэгч (“Монголын цахилгаан холбоо” ХК нь орон нутгийн 3 суваг, “Эн Би Си” ХХК нь ОХУ-н 4 суваг) байгаа бөгөөд энэ нь тухайн сувгуудын хувьд чанар, дохионы алдагдал үүсэх эрсдэлтэй тул зөрчил дутагдлыг арилгаж ажиллах талаар сануулсан.

Түүнчлэн телевизийн сувгийг ОТТ технологиор дамжуулан хүргэх үед битийн хурдыг хэрэглэгчийн сүлжээний нөхцөлд нийцүүлэн автоматаар тохируулах (adaptive bitrate) боломжийг бүрдүүлээгүй 1 үйлчилгээ эрхлэгч (“Эн Би Си” ХХК) байна. Энэ нь хэрэглэгчийн сүлжээний хурд, чанараас хамааран дүрс, дууны тасалдал үүсэх, үйлчилгээний чанар тогтворгүй болох эрсдэл үүсгэнэ.

ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн дийлэнх нь хэрэглэгчдэд үйлчилгээтэй холбоотой мэдээллийг хүргэхдээ дуудлагын төв болон албан ёсны цахим хуудсыг тогтмол ашиглаж байна. Үүнээс гадна зарим үйлчилгээ эрхлэгч хэрэглэгчийн бүртгэлтэй цахим шуудангийн хаяг болон гар утасны дугаарт мэдэгдэл, мэдээллийг шууд хүргэх хэлбэрийг нэвтрүүлсэн нь мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хэрэглэгчтэй харилцах сувгийг өргөжүүлсэн сайн талтай.

Хэрэглэгчийн дуудлага, өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбоотой дотоод зохицуулалтын хэрэгжилтийг авч үзэхэд нийт 12 үйлчилгээ эрхлэгч бүгд холбогдох журмыг батлан мөрдөж байна. Үүнээс олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн хувьд хэрэглэгчээс ирүүлсэн дуудлага, өргөдөл, гомдолд 24 цагаас багагүй хугацаанд хариу өгөх зохицуулалтыг журамдаа тусган мөрдөж байгаа бол радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгч нь 48 цагаас багагүй хугацаанд хариу өгөх шаардлагыг журамдаа тусган хэрэгжүүлж байна. Энэ нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэх тогтолцоо тодорхой хэмжээнд бүрдсэнийг илтгэнэ.

Мөн бүх үйлчилгээ эрхлэгч зохисгүй агуулгатай контент, телевизийн сувгийг хязгаарлах зорилгоор эцэг, эхийн хяналтын (parental control) функцийг үйлчилгээндээ нэвтрүүлжээ. Түүнчлэн уг функцыг ашиглах заавар, зөвлөмжийг хэрэглэгчдэд зориулсан гарын авлага болон албан ёсны цахим хуудсаар дамжуулан хүргэж байгаа нь хүүхэд хамгаалал, контентын зохистой хэрэглээг дэмжих чиглэлд чухал ач холбогдолтой юм.

РАДИО, ТЕЛЕВИЗИЙГ ДАМЖУУЛАХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХАД ТАВИХ ШААРДЛАГА:

№	Үйлчилгээ эрхлэгч	Дотоодын тв суваг			Гадаадын тв суваг		
		Дотоод сувгийн тоо	Гэрээ байгуулсан сувгийн тоо	Гэрээтэй сувгийн тоо хувиар %	Гадаад сувгийн тоо	Гэрээ байгуулсан сувгийн тоо	Гэрээтэй сувгийн тоо хувиар %
Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч							
1	“Монголын цахилгаан холбоо” ХК	57	17	29.8%	32	5	15%
2	“Монголсат нэтворк” ХХК	73	45	62%	26	23	88%
3	“Сансар Дижитал” ХХК	57	17	30%	32	17	53%
4	“Шинэ сансар кабель” ХХК	56	45	63%	31	10	32%
5	“Мобинет” ХХК	74	74	100%	44	44	100%
6	“Юнивишн” ХХК	96	52	54%	77	77	100%
7	“Скаймедиа корпораци” ХХК	64	44	69%	59	38	64%
8	“ДДэш ТВ” ХХК	68	45	66%	49	47	96%
9	“Оптимум нэтворк” ХХК	37	-	0%	17	-	0%
10	“Ори медиа” ХХК	22	15	68%	-	-	-
11	“Эн Би Си” ХХК	59	45	76%	36	23	64%
Нийт		663	399	60%	403	284	70%
Радио, телевизийн газрын сүлжээ							
12	“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ	21	21	100%	-	-	-

Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын журмын шаардлага:

№	Үйлчилгээний нэр	Үндсэн багцын тв сувгийн дараалал	Гадаадын тв сувгийн эзлэх хувь	Гадаадын аль нэг улсын тв сувгийн эзлэх хувь
1	Монголын цахилгаан холбоо ХК	Гадаадын телевизийн суваг нь дотоодын телевизийн сувгуудын дунд байрласан	27%	41%
2	Монголсат нэтворкс ХХК	Шаардлага хангана	Гадаадын ТВ суваг байхгүй	
3	Сансар Дижитал ХХК	Гадаад болон арилжааны телевизийн суваг холилдсон	35%	40.6%
4	Шинэ сансар кабель ХХК	Гадаадын телевизийн суваг нь дотоод телевизийн сувгийн дунд байрласан	35%	32%
5	Мобинет ХХК	Шаардлага хангана	Гадаадын ТВ суваг байхгүй	
6	Юнивишн ХХК	Дотоодын телевизийн суваг гадаадын телевизийн сувгийн дунд байрласан	31%	23%
7	Скаймедиа корпораци ХХК	Шаардлага хангана	Гадаадын ТВ суваг байхгүй	
8	ДДэш ТВ ХХК	Шаардлага хангана	30%	21%
9	Оптимум нэтворк ХХК	Шаардлага хангана	32%	23%
10	Ори медиа ХХК	Шаардлага хангана	Гадаадын ТВ суваг байхгүй	
11	Эн Би Си ХХК	Шаардлага хангана	26%	38%

Дүгнэлт: Төлөвлөгөөт хяналтад хамрагдсан үйлчилгээ эрхлэгчдийн дийлэнх нь холбогдох хууль, журам, техникийн стандарт, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг ханган, үйлчилгээний чанар, найдвартай ажиллагаа, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр зохих түвшинд ажиллаж байна. Ялангуяа дуу, дүрсний чанар, тоног төхөөрөмжийн үзлэг, үйлчилгээний тогтолцоо, хэрэглэгчийн гомдол шийдвэрлэлт, эцэг, эхийн хяналтын систем зэрэг үзүүлэлтүүдийн хангасан.

Гэвч зарим үйлчилгээ эрхлэгчдийн хувьд техникийн нөөц бүрдүүлэлт, гамшгийн үеийн мэдээлэл дамжуулах бэлэн байдал, тасралтгүй ажиллагааны тайлагналт, дотоод журам, хэмжилт, тохируулгын зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй, мөн тодорхой технологийн шийдлүүдийг (жишээлбэл adaptive bitrate) бүрэн нэвтрүүлээгүй зэрэг дутагдал илэрсэн нь цаашид үйлчилгээний чанар, найдвартай байдлыг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Түүнчлэн радио, телевизийг дамжуулах, гэрээ байгуулахад тавих шаардлагын хүрээнд дийлэнх үйлчилгээ эрхлэгч гадаад, дотоодын телевизийн сувгуудтай бүрэн гэрээ байгуулаагүй байгаа нь Өргөн нэвтрүүлгийн тухай хууль болон олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын холбогдох заалтуудыг бүрэн хангахгүй байна. Иймд дамжуулж буй телевизийн сувгуудтай үе шаттайгаар гэрээ байгуулж, гэрээтэй сувгийн тоог нэмэгдүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай.

Мөн Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын журамд заасан шаардлагын хэрэгжилтийг авч үзэхэд сувгийн дарааллыг журамд нийцүүлэн байршуулаагүй 4, гадаадын телевизийн сувгийн эзлэх хувь тогтоосон хэмжээнээс хэтэрсэн 4, түүнчлэн гадаадын аль нэг улсын телевизийн сувгийн эзлэх хувь нь нийт гадаад сувгийн 30 хувиас хэтрэхгүй байх шаардлагыг хангаагүй 4 үйлчилгээ эрхлэгч тус тус байна.

Иймд Зөвшөөрлийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль болон эдгээрт нийцүүлэн ХХЗХ-ноос баталсан нөхцөл, шаардлага, журмын



хэрэгжилт, тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн биелэлтийг хангаагүй үйлчилгээ эрхлэгчдэд илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, хууль тогтоомж, тусгай зөвшөөрлийн гэрээний заалт бүрээр хэрэгжилтийг хангаж ажиллах талаар зөвлөмж, мэдэгдэл хүргүүлэн ажиллаа.